



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2020 оны 08 сарын 26 өдөр

Дугаар

9/374

Арвайхээр

Тарваган тахлын сэжигтэй тохиолдлын  
үед авах арга хэмжээний тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5.в, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.4, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалт, аймгийн Онцгой комиссын 2020 оны 08 дугаар сарын 26-ны өдрийн 11 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Арвайхээр сумын нутаг дэвсгэрт гоц халдварт тарваган тахлын сэжигтэй тохиолдол илэрсэн тул голомтод ажиллах шуурхай ажлын хэсэг байгуулах, аймгийн гамшгаас хамгаалах албад холбогдох мэргэжлийн ангиудын бэлтгэл, бэлэн байдлыг хангуулж, гамшгийн үеийн үүрэгт ажилд нь шилжүүлж мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, Тарваган тахлаас урьдчилан сэргийлэх сурталчилгааг хэвлэл мэдээллийн хэрэгслэлээр давтамжтайгаар зохион байгуулахыг аймгийн Онцгой байдлын газар (дэд хурандаа Т.Мөнхдорж)-т үүрэг болгосугай.

2.Гоц халдварт тарваган тахал өвчний сэжигтэй тохиолдлын нэгдүгээр хавьтлыг илрүүлж, эрүүл мэндийн үзлэг, шинжилгээ, урьдчилан сэргийлэх эмчилгээг тогтмол хийж иргэдэд халдвар хамгааллын дэглэмийг чанд сахиулан ажиллахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Эрүүл мэндийн газар (Д.Шивааннүрдэв), Бүсийн оношилгоо эмчилгээний төв (Д.Мөнхнасан), Зоонозын өвчин судлалын төв (Б.Сүхбаатар), аймгийн Цагдаагийн газар (цагдаагийн хурандаа О.Ганбат), аймгийн Тагнуулын хэлтэс (О.Баярлхагва)-т тус тус даалгасугай.

3.Гоц халдварт тарваган тахал өвчний сэжигтэй тохиолдол бүртгэгдсэнтэй холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2017 оны “Заавар батлах тухай” 160, 161 дүгээр тушаалыг мөрдлөг болгон ажиллахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Эрүүл мэндийн газар (Д.Шивааннүрдэв), Зоонозын өвчин судлалын төв (Б.Сүхбаатар), Бүсийн оношилгоо эмчилгээний төв (Д.Мөнхнасан) нарт тус тус үүрэг болгосугай.

4.Халдвар авсан эх сурвалжийг цаг алдалгүй шуурхай судлан, тогтоож ажиллахыг аймгийн Цагдаагийн газар (цагдаагийн хурандаа О.Ганбат), аймгийн Тагнуулын хэлтэс (О.Баярлхагва)-т үүрэг болгосугай.

011100833

5.Тарваган тахлын голомт бүхий зарим сумдад нийгмийн хэв журмыг сахиулж, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажил зохион байгуулах, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд хяналт тавих ажлыг зохион байгуулахыг аймгийн Цагдаагийн газар (хурандаа О.Ганбат)-т үүрэг болгосугай.

6.Богд сумын төвийн гарах хөдөлгөөнд хязгаарлалт тогтоож ажиллахыг Богд сумын Засаг дарга, сумын Онцгой комиссын дарга (Ч.Чинзориг)-д үүрэг болгосугай.

7.Нэгдүгээр хавьтал бүхий Богд сумын нэр бүхий иргэний гэрт болон аймгийн Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн Халдвартын эмнэлэгт байнгын пост, ажлын хэсэг ажиллуулж, зохих дээж, арчдас авч, шинжилгээ хийх, шаардлагатай хаягдлыг устгах, ариутгах арга хэмжээ авч ажиллахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Зоонозын өвчин судлалын төв (Б.Сүхбаатар)-д даалгасугай.

8.Нэг, хоёрдугаар хавьтал тогтоох, үзлэг шинжилгээ хийх алба хаагчдын аюулгүй байдлыг хангах, халдвар, хамгааллын хувцас хэрэгслээр хангах, заавар, зөвлөмж өгч ажиллахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Эрүүл мэндийн газар (Д.Шивааннүрдэв)-т даалгасугай.

9.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Онцгой комиссын орлогч, Онцгой байдлын газрын дарга (дэд хурандаа Т.Мөнхдорж)-д үүрэг болгосугай.

ОРЛОГЧ  О.БАТЖАРГАЛ